

РИО ТИНТО ХХК-ИАС ОЮУ ТОЛГОЙ ХХК-НД ҮЗҮҮЛЖ БУЙ УДИРДЛАГЫН ҮЙЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ (MSP)-ИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Олон улсын хэмжээнд хамтарсан уул уурхайн компаниудын үйл ажиллагааг үр ашигтай, зөв зохистой удирдан зохион байгуулж, хувь нийлүүлэгчдийн ногдол ашгийг хамгийн боломжит дээд түвшинд хүргэх үүднээс энэ салбартаа туршлагатай, амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаар удирдуулан, авсан үйлчилгээндээ төлбөр төлөх туршлага нилээд нийтлэг байдаг байна.

Эрдэнэс МГЛ ХХК, Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд, Оюу Толгой Нидерланд Би.Ви., Оюу Толгой ХХК (хуучин нэрээр Айвенхоу Майнз Монголия Инк ХХК) нарын хооронд байгуулсан Оюу Толгойн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс барилгын ажил болон компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах багаар Рио Тинто компанийг сонгон томилсон.

Рио Тинто нь олон улсын тэргүүлэгч уул уурхайн компанибөгөөд дэлхийн хэмжээнд маш өндөр үр ашигтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниудын тоонд ордог билээ. Ийм ч учраас Оюу Толгой төслийг өндөр үр ашигтай, амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л туршлагыг эзэмшсэн байдал, бусад хүчин зүйлийг харгалзан үзэж тус компанийг төслийн удирдагч байгууллагаар сонгоход шийдвэрлэх нөлөө үзүүлсэн билээ.

Рио Тинтогийн олон жилийн туршид хуримтлуулсан арвин туршлага, үйл ажиллагааныхаа явцад бий болгож, сайжруулан хэрэглэж буй дотоод систем, дүрэм журам болон ноу-хау-г Оюу Толгой ХХК-д нэвтрүүлэх

бүрэн боломж бүрдээд байна. Рио Тинто нь төслийн нийт үйл ажиллагааг удирдан явуулахад шаардлагатай боловсон хүчин, зохистой бүтэц, зохион байгуулалтаар ханган, менежментийн үйлчилгээний хүрээнд 5 үндсэн чиглэлээр 30 гаруй үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах болно (Хавсралтаас үзнэ үү).

Олон улсын хэмжээнд уул уурхайн салбарт удирдлагын үйлчилгээний шимтгэл (УҮШ)-ийг тооцох олон аргууд байдгаас орлогын болон зардлын хувиар тооцох аргууд түгээмэл хэрэглэгддэг байна. Орлогоос УҮШ-ийг тооцоход 1-3 хувийг хэрэглэдэг бөгөөд Рио Тинто компаниас Оюу Толгой ХХК-д үзүүлж буй үйлчилгээтэй харьцуулахад маш цөөн тооны нэр төрлийг хамардаг байна. Тухайлбал, ихэнх тохиолдолд орлогод суурилсан УҮШ-д зөвхөн маркетингийн үйлчилгээ орж, бусад үйлчилгээг тусдаа үнэ төлбөртэйгээр худалдан авдаг байна.

Хэрэв энэ аргыг Оюу Толгойн төсөлд хэрэглэн орлогын 2 хувиар УҮШ-ийг тогтоосон бол ашиглалтын жилүүдэд 80-140 сая ам. долларын төлбөр төлөх тооцоо гарч байна. Энэ нь зардалд суурилсан УҮШ-ээс хамаагүй өндөр шимтгэл юм. Түүнчлэн, орлогод суурилсан УҮШ зах зээлийн үнийн өөрчлөлтөд хэт мэдрэг байдаг нь төлөвлөсөн хэмжээнээс орлого их хэмжээгээр буурах магадлалыг бий болгож хувьцаа эзэмшигчдэд тодорхойгүй байдлыг үүсгэдэг байна.

Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын үйлчилгээ үзүүлэгчийн хооронд УҮШ-ийг тохирох хэлэлцээрийг бусад

РИО ТИНТО ХХК-ИАС Оюу Толгой ХХК-НД ҮЗҮҮЛЖ БУЙ УДИРДЛАГЫН ҮЙЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ (MSP)-ИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА (Үргэлжлэл)

худалдан авалтын үйл ажиллагаатай ижил зарчмаар явуулсан бөгөөд зардалд суурилсан УҮШ-ийг талуудын хувьд харилцан үр ашигтай гэж сонгосон юм. Хувьцаа эзэмшигчидийн гэрээнд УҮШ-ийг үйлдвэрлэл эхлэхээс өмнөх хугацаанд хөрөнгийн болон үйл ажиллагааны нийт зардлын 3 хувиар, үйлдвэрлэл эхэлснээс хойших хугацаанд 6 хувь байхаар харилцан тохиролцож, төлбөрийг улирал бүр хийж гүйцэтгэхээр болсон.

Төслийн үргэлжлэх нийт хугацаанд удирдлагын цогц үйлчилгээ нь төлж буй төлбөртэй харьцуулахад арав дахин илүү өгөөжтэй юм. Жишээлбэл, бүрэн хүчин чадлаар ажиллах үед Рио Тинто компанийн удирдлагын үйлчилгээ нь хувьцаа эзэмшигчдэд очих мөнгөн урсгалыг 1-2 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэх бөгөөд ийм үр дүнд хүргэснийхээ төлбөрт 60-80 сая ам.долларыг авах болно. Үйл ажиллагааны чиглэл бүрийн хувьд дараах давуу тал, амжилтанд хүрээд байна. Үүнд:

- 1. Төслийн удирдлага** - Рио Тинто компанийн зөв төлөвлөлт, түргэн шуурхай гүйцэтгэлийн үр дүнд барилгын ажлыг богино хугацаанд буюу төлөвлөсөн хугацаанаас 12 сарын өмнө бүрэн хийж гүйцэтгэх бөгөөд энэ нь ойрын хугацааны бэлэн мөнгөний урсгалыг 1 тэрбум гаруй ам. доллараар нэмэгдүүлэх нөлөө үзүүлэх болно.
- 2. Уурхайн үйл ажиллагаа** – Уламжлалт олборлолтын аргатай харьцуулахад нилээд нарийн төвөгтэй боловч олборлолтын зардлын хувьд маш хямдад тооцогддог Рио Тинтогийн “блокчилон олборлох” аргыг Оюу Толгой төслийн хүрээнд ашиглах

бөгөөд олон улсын хэмжээнд цөөн хэдэн компани энэ аргаар олборлолт явуулдгаас Рио Тинто компани шилдэгт нь зүй ёсоор тооцогддог. Түүнчлэн, энэхүү арга нь бусад аргатай харьцуулахад нилээд хэдэн жилийн өмнө уурхайг бүрэн хүчин чадлаар ажиллах боломжийг олгодог бол нэг тонн хүдэр олборлох зардлыг 3 дахин бууруулж, нийт ашгийг их хэмжээгээр өсгөдөг байна.

- 3. Маркетинг** - Оюу Толгой ХХК нь Рио Тинто компанийн олон улсын хэмжээний туршлага, нэр хүндийн үр дүнд Монголд анх удаа зэсийг олон улсын үнээр борлуулах боломжтой болсон буюу Рио Тинто компани нь бусад Монголын зэс олборлогчидтой харьцуулахад илүү ашигтай нөхцөлөөр бүтээгдэхүүнээ борлуулах гэрээ байгуулж чадсан юм.
- 4. Худалдан авалт** - Олон улсын хэмжээн дэх худалдан авалтдаа Оюу Толгой компани ердийнхөөс бага үнэ төлж байгаа нь Рио Тинто компанийн худалдан авах үйл ажиллагааны нэр хүнд, төрөл, хэмжээ, үнэ тохиролцох арга туршлага, олон улсын ханган нийлүүлэгчидтэй тогтоосон хамтын ажиллагааны үр дүн юм. Жишээлбэл, хэрэв Оюу Толгой ХХК Рио Тинто компанийн удирдлагагүйгээр дангаараа үйл ажиллагаагаа явуулж байсан тохиолдолд одоогийн худалдан авч байгаа үнэтэй харьцуулахад уул уурхайн машин техникийг 40 хувь, шатахууныг 9 хувиар илүү өндөр үнээр худалдан авах байлаа.
- 5. Үйл ажиллагааны/ашиглалтын стандарт** - Рио Тинтогийн удирдлага нь Оюу Толгой төслийн хүрээнд үйл ажиллагааны, аюулгүй ажиллагааны, байгаль орчны олон улсын шилдэг стандартуудыг хэрэгжүүлж,

РИО ТИНТО ХХК-ИАС Оюу Толгой ХХК-НД ҮЗҮҮЛЖ БУЙ УДИРДЛАГЫН ҮЙЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ (MSP)-ИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА (Үргэлжлэл)

хэвшүүлж байна. Энэ нь өөрийн ажилтнууд болон байгаль орчныг хайрлан хамгаалахын зэрэгцээ олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт авах баталгаа болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, дэлхийн шилдэг стандартуудыг хэрэгжүүлэх нь Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтыг бий болгоход шаардлагатай санхүүжилтийг харьцангуй бага хүүтэйгээр, хангалттай хэмжээгээр авах бололцоог бүрдүүлж байна.

Рио Тинто компанийн үзүүлж буй удирдлагын үйлчилгээ нь төслийн үйл ажиллагаанаас гадна нилээд үр ашгийг өөр бусдад бий болгож байна. Тухайлбал, Оюу Толгойн 3,000 ажилтнуудад олон улсын хэмжээний сургалтыг явуулахын зэрэгцээ Монгол орны хэмжээнд мянга гаруй ажилчид, багш нарын сургалтанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн түүнчлэн орон нутгийн

компаниудад Оюу Толгой төслөөс хүртэх боломжуудыг ашиглахад нь тусалж байна.

Сүүлийн үед олон нийтийн дунд Рио Тинто компани нь зардлыг өсгөх замаар өөрийн ашгийг нэмэгдүүлж байна гэсэн ташаа ойлголт нэмэгдэх хандлагатай байна.

Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэхийн хирээр Рио Тинто компанийн авах ногдол ашгийн хэмжээ буурч, санхүүжилтийн зардал эрс нэмэгдэх сөрөг үр дагавартай байдаг. Жишээбэл, хөрөнгийн зардал болон ашиглалтын зардал 20 хувиар нэмэгдвэл хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөж буурч ашигт малтмал ашигласны төлбөр, НӨАТ болон бусад татвар хураамжийн өсөлтөөс үүдэлтэйгээр Засгийн газрын хүртэх хувь хэмжээ 75 хувиас 100 хүртэл хувиар нэмэгдэх билээ.